



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/112

Жаргалант

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор хуучин цэцэрлэгийн байрыг төрийн албан хаагчдын орон сууц болгон тохижуулах засварын ажлын хөлсөнд 8,000,000 (найман сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ